



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№226 /435/

2022.12.14

Цаг үе, үйл явдал

## ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГЭЭР БХЯ ТЭРГҮҮЛЭН АЖИЛЛАЛАА



Өнөөдөр Батлан хамгаалахын хяналт шалгалтын нэгжүүд хуралдаж 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ болоод цаашид хэрэгжүүлэх хяналт шалгалтын бодлого тодотгохын зэрэгцээ алдаа оноо, амжилт бүтээлээ дүгнэлээ. Уг хуралд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын алба, БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Зэвсэгт

хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, Тээврийн хяналтын албаны төлөөлөл оролцлоо. Хяналт шалгалтын нэгжүүд ажлаа тайлагнасны дараа Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ "Батлан хамгаалахын нэгдмэл хяналт" бодлогын хүрээнд хяналт шалгалтын нэгжүүд нэгдсэн, зөв зорилго, зорилтын дор гүйцэтгэл, үйл ажиллагаагаа төлөвлөн

хэрэгжүүлснээр ажлын уялдаа холбоо, сайжирч, шалгалтын давхцал арилсан, салбарын гүйцэтгэлд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтэд хийдэг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр дамжуулан бодитой нөлөөлж байгаагийн илрэл нь Батлан хамгаалах яам 2021 оны ажлын гүйцэтгэлээр яамдыг тэргүүлсэн явдал болохыг онцлоод дараах үүрэг чиглэлийг бие бүрэлдэхүүнд өглөө.



**Үүнд:**  
-Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас баталсан холбогдох журмууд болон Батлан хамгаалахын сайдын 2020 оны тушаалын хэрэгжилтэд онцгой анхаарч ажиллах;  
-Албан тушаалтан бүр захирах, захирагдах ёсыг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заагдсан үүрэг бүрийн хүрээнд хийгдэх ажлуудаа орхигдуулалгүй төлөвлөж, зохион байгуулах;  
-Зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах бүх талын арга хэмжээг

хэрэгжүүлэх;  
-Тээврийн хэрэгслийн оношилгоо, бүртгэл, хяналтын системийг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;  
-Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагуудад цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчил, гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар хүргүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулахад бүх шатны хяналтын байгууллагууд анхаарах зэрэг үүрэг чиглэлийг өгсөн юм.

## ХУРАНДАА Х.ЭРДЭНЭЧИМЭГ БНСУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ ХЭЛНИЙ ИНСТИТУТИЙГ АЛТАН МЕДАЛЬТАЙ ТӨГСЛӨӨ



Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэлтээрээ манлайлж, дэлхийн орнуудын цэргийн их сургуульд сурлага, сахилгаараа тэргүүлсээр байна. Тухайлбал ОХУ, БНХАУ, АНУ, Япон, БНСУ, БНТУ зэрэг улсын цэргийн сургуульд суралцаж байгаа офицер, ахлагч, сонсогчийн олонх нь тэргүүлэгч болж эх орныхоо нэрийг дурсгасаар байгаа бөгөөд үүний залгамж түүчээг хурандаа Х.Эрдэнэчимэг саяхан буухиалжээ. Тэрээр БНСУ-ын Батлан хамгаалахын хэлний институтийг алтан медальтай төгсөж, дипломоо гардан авсан байна. Институтийн захирал төгсөгчдөд хандаж хэлсэн үгэндээ үе үеийн монгол офицерууд манлайлагч байж чаддагийг онцлоод цаашдынх нь сурлага, ажил хөдөлмөрт өндөр амжилтыг хүсэн ерөөжээ. Хурандаа бүсгүй үргэлжлүүлэн БНСУ-ын Үндэсний Батлан хамгаалах Их сургуулийн Аюулгүй байдлын дамжаанд суралцана.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-20	-32

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.448	3.452
EUR	3.646	3.665
CNY	492	494
RUB	52.10	52.50
JPY	25.20	25.50
KRW	2.63	2.66

### ЗУРХАЙ

2022.12.14 / ЛХАГВА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 21

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Өвчин ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.34-16.59  
Барилдлага: Үхэх  
Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол  
Нийт: 654,855,973

Эдгэрсэн  
Нийт: 629,948,438

Нас барсан  
Нийт: 6,661,947

## ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЭХ ОРНООСОО МОРДЛОО



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагааны 12 дугаар ээлжид үүрэг гүйцэтгэж буй хурандаа Н.Эрдэнэбаяр захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны гурав дахь цуврааны бүрэлдэхүүн энэ сарын 13-ны үдэш ажиллагааны газар орныг зорилоо.

Тус мотобуудлагын батальоны эхний ээлжийн бүрэлдэхүүн 11 дүгээр сарын 15-ны өдөр, хоёр дахь цуврааны бүрэлдэхүүн 12 дугаар сарын нэгний өдөр Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсыг зорьсон бол энэхүү гурав дахь ээлжид томилогдсон офицер, ахлагч нар өнөөдөр эх орноосоо мордож буй нь энэ юм.

Эдгээр бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг "Чингис хаан" олон улсын нисэх буудлаас хүндэтгэн үдэж, амжилт хүссэн юм.

Бригадын генерал С.Дашзэвэг энэ үеэр хэлсэн үгэндээ "Өнөөдөр төр, засаг, цэргийн дээд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг амжилттай биелүүлэн, эх дэлхийн энх амгалангийн үйлсэд өөрсдийн



хувь нэмрээ оруулж, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр эх орноосоо мордож буй Та бүхэндээ ЗХЖШ-ын удирдлагын зүгээс болон хувиасаа баяр хүргэе. Та бүхэн цаг агаарын болон цагийн байдлын хүнд нөхцөлд өмнөх 11 ээлжийн мотобуудлагын батальоны нийт бие бүрэлдэхүүний ололт амжилт, нэр хүндийг улам бүр бататгаж, үүргээ нэр төртэй гүйцэтгэж чадна гэдэгт итгэл төгс байна. Энэ удаа ажиллагааны газар орныг зорьж байгаа гурав дахь цуврааны бүрэлдэхүүний нэг онцлог нь 40 гаруй эмэгтэй цэргийн алба хаагч нэг дор үүрэг гүйцэтгэхээр

явж байгаад оршино. Тодруулбал, тус батальоны нийт цэргийн алба хаагчдын дотор 90 гаруй эмэгтэй цэргийн алба хаагч сонгон шалгаруулалтад тэнцэж, ажиллагааны өмнөх сургалтад амжилттай хамрагдсан төдийгүй ажиллагааны газар орныг зорьж байгаагаараа онцлогтой. Ингэснээр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлийн үеэр хэлсэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын дагуу Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог нэмэгдүүлж 15 хувьд хүргэх чиглэлийг баримталж байгаа гэсэн амлалтыг бодит ажил хэрэг болгох ажлын эхлэлийг тавьж буй нь энэ юм. Иймд тус батальоны бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх эмэгтэй алба хаагчдын хувьд бусдыгаа манлайлж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган үүрэг гүйцэтгэхийг шаардаж байгаа" гэдгийг онцлоод нийт бие бүрэлдэхүүнд амжилт бүхний дээдийг ерөөсөн юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

## ЦЭРГИЙН БАГУУДЫН ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦЭХ, ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА БОЛЛОО



Эрх шилжүүлэх ажиллагааны үеэр ажлын хэсгийн дарга бригадын генерал Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ, Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад ирээд гурван сектор командлагч, НҮБ-ын мужийн зохицуулагч, болон хамтран үүрэг гүйцэтгэж буй бусад улсын цэргийн багийн бүрэлдэхүүнтэй уулзлаа. Уулзалтын үеэр Монгол цэргийн хөдөлмөрч, хариуцлагатай үүргээ гүйцэтгэдэг байдалд өндөр үнэлгээ өгч буйг олонтой сонслоо. Бид ямар нэг зүйл болвол Монгол цэрэгт хамгийн их итгэнэ гэсэн магтаалын сайхан үг сонсож байхдаа Монгол улсынхаа нэрийг өндөрт өргөж яваа цэргийн алба хаагчид болон тэр дундаа хурандаа О.Заяат захирагчтай XI ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнээр чин сэтгэлээсээ баярлаж, бахархаж байлаа.

Ажиллагааны газар оронтой биечлэн танилцаж явахад дотоодын дүрвэгсдийн хуарангийн орон нутгийн иргэн Монгол цэрэг байгаа болохоор би өнөөдөр амьд байна гэж ярьж буйтай ч таарлаа. Ээлж хүлээж авч буй хурандаа Н.Эрдэнэбаяр захирагчтай XII мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд ажлын амжилт хүсье, үүргээ амжилттай гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна гэв.

Юнити мужийн сектор командлагч бригадын генерал Купер Майк Мужуни хэлсэн үгэндээ, Би Монгол цэргүүдэд итгэдэг. Ямар нэг зүйл болоход Монгол цэргүүд хамгийн хариуцлагатай, шийдэмгий байдаг. Монгол цэргүүдтэй хамтарч ажиллахад хүндрэл байдаггүй. Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр биелүүлдэг сайн хамтрагч байж чаддаг. Хурандаа О.Заяат хариуцлагатай сайн багаа удирдсан гэж би дүгнэж байна.



бие бүрэлдэхүүндээ ажлын амжилт хүсье, хүний нутагт бие биеэ хүндэлж, хайрлаж, дэмжиж нэг баг хамт олон болж, үүргээ нэр төртэй биелүүлэхийг хүсье. Монгол цэргийн яруу алдар бадартугай, Монгол улсын төлөө зүтгэе. XII ээлжийн мотобуудлагын захирагч хурандаа Н.Эрдэнэбаяр хэлсэн үгэндээ, Энэхүү тамгыг дарж, гаргаж байгаа шийдвэр бүхэн цэргийн алба хаагчдын эрх ашиг, зөв шийдвэр бүхэн дээр дарагдана гэдгээ амлаж байна гэсэн юм.

Энэ удаагийн ажил хүлээлцэж, эрх шилжүүлэх ажиллагааг анх удаа Батлан хамгаалах яамнаас ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг томилсноороо онцлог байлаа.

Хэвлэл мэдээллийн төлөөлөгч: Ахлах дэслэгч П.БАЯЛАГМАА

### Сургалт


## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №37

### ПА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

ПА бол дэвсгэр бус үсэг. Бүтцийн хувьд, өмнө үзсэн БА үсгийнх шиг нурууны шугам дээр гэдэс зурж зүүн дээш эргүүлсхийн задгай орхиод, үзгээ салган нум зурж нуруутай нийлүүлэн бичдэг. Төгсгөлийн "ПИ" үеийн "И"-гийн нумыг бичихдээ нуруун дээр нь дөрвөлжиндүү хэлбэрээр гаргадаг. ПА үсэг монгол хэлний авиа болон дүрс дуурайх цөөвтөр бүхэн цэрэг бөгөөд бусад үед харь үгийг тэмдэглэхэд хэрэглэдэг.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ПА, ПЭ, ПИ, ПО, ПУ, ПӨ, ПҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:



Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын XI, XII мотобуудлагын батальоны ээлж хүлээлцэж, эрх шилжүүлэх ёслолын ажиллагааг өчигдөр /2022 оны 12 дугаар сарын 13/ "Хубилай" баазад зохион байгууллаа.

Ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Юнити секторын командлагч бригадын генерал Купер Майк Мужуни, секторын орлогч дарга хурандаа Аммар Ашража, Гана улсын МББ-ын захирагч дэд хурандаа Мандо, зэвсэглэсэн цагдаагийн дарга хурандаа Далий Марксан, Вьетнам улсын хээрийн II шатлалын эмнэлгийн дарга дэд хурандаа Мийг Дуаиг, Пакистан улсын инженерийн ротын орлогч дарга хошууч Вакас.М болон албаны бусад хүмүүс оролцов.



Шинэ багийн захирагч үргэлжлүүлэн бидэнтэй хамтарч, олон ажлыг хийнэ гэдэгт итгэж байна. Монгол цэрэгтэй хамтарч ажиллахад итгэл алддаггүйг дахин хэлмээр байна. Та бүхэнд сайн сайхныг хүсье гэв.

XI ээлжийн мотобуудлагын батальоны захирагч хурандаа О.Заяат хэлсэн үгэндээ, XI ээлжийн мотобуудлагын батальон ажиллагааны газар оронд үүргээ амжилттай дуусгаж, өнөөдөр албан ёсоор эрх, үүргээ шилжүүлж байна. Манай цэргийн баг үер, усны нөхцөл байдал үссэн хүнд цагт мөн Ковид-19 цар тахлын үед үүрэг гүйцэтгэсэн нь онцлог байлаа. Олон бүтээлч ажлыг хийж цэргийн дээд удирдлагаас өгсөн үүргийг нэр төртэй гүйцэтгэлээ. Энэ бол хамтран үүрэг гүйцэтгэсэн офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч та бүхний хичээл, зүтгэл, хамтын хүч юм. Та бүхэндээ баярлалаа. Удирдлагаар хангаж хамтран ажилласан секторын командлагч, штабын хамт олондоо баярлалаа.

Үүргээ хүлээж авч буй XII ээлжийн мотобуудлагын батальоны